



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/306

Эрдэнэт

Хуваарилалт хийх тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1/а/, 29.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 02 дугаар тогтоол, 2017 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаар тогтоолын 1.4.1 дэх заалт, аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлын 2017 оны ээлжит 7,8 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор “Эрдэнэтчүүд Эрдэнэчүүдээ хайртай” дэд хөтөлбөрийн зардлыг 200,0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1 дүгээр хавсралтаар, “Эмч” дэд хөтөлбөрийн зардлыг 96,0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 2 дугаар хавсралтаар, “Багш” дэд хөтөлбөрийн зардлыг 97,0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 3 дугаар хавсралтаар, “Ач санах” хөтөлбөрийн зардлыг 55,0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 4 дүгээр хавсралт, “Багийн хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийн зардлыг 54,3 сая төгрөгөөр нэмэгдүүлж 5 дугаар хавсралтаар, “Өрхийн тариалалтыг дэмжих” дэд хөтөлбөрийн зардлыг 100,0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 6 дугаар хавсралтаар, “Чөлөөт цагийн талбай” дэд хөтөлбөрийн зардлыг 140,0 сая төгрөгөөр 7 дугаар хавсралтаар, Ус дэд хөтөлбөрийн зардлыг 150,0 сая төгрөгөөр 8 дугаар хавсралтаар тус тус баталж хуваарилсугай.

2. Хуваарилсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Бямбацэцэг/-т, хуваарилсан зардлын дагуу Худалдан авах үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газар /н.Оюунгэрэл/-т тус тус даалгасугай.

3. Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /н. Соёлчхүү/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

D:\zahiramj/A-4.doc
0200001478